



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
http://www.mojha.gov.mn

2017.06.27 № 1-1/2688

танай 2017.08.23-ны № 01/194 -Т

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН  
АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ  
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА Э.ПҮРЭВЖАВ ТАНАА

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн "Аж ахуйн харилцааны дүрмийг шинэчлэн батлах тухай" 2017 оны 74 дүгээр тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 3744 дугаарт бүртгэснийг мэдэгдье.



С.БЯМБАЦОГТ

08.18287  
Doc said as 2017



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
2017. оны 06. сарын 17-ны  
өдрийн 374 дугаарт бүртгэв.

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,  
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,  
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 74

Улаанбаатар хот

Аж ахуйн харилцааны  
дүрмийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.13, 10 дугаар зүйлийн 10.1.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэхь заалт, тус Зохицуулах зөвлөлийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн аж ахуйн харилцааны дүрэм"-ийг нэгдүгээр, "Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцааны дүрэм"-ийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тогтоослын хэрэгжилтэнд хяналт тавьж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба /Б.Доржбат/, Тусгай зөвшөөрлийн алба /Л.Хишигдулам/, Үнэ тарифын алба /Ж.Гэрэлчулуун /-нд тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан тус Зохицуулах зөвлөлийн 2013 оны 06 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тогтоолыг эс зөвшөөрвөл Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА

Э.ПҮРЭВЖАВ

ГИШҮҮН

Б. ЖИГЖИД

Ч. БАТТОГТОХ

С. ЧУЛУУНХУЯГ

Р. НЯМЖАВ

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 74 тоот тогтоолын нэгдүгээр хавсралт

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ, ХЭРЭГЛЭГЧ ХООРОНДЫН АЖ АХУЙН ХАРИЛЦААНЫ ДҮРЭМ

### 1. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү дүрмийн зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллага /хангагч/ болон үйлчилгээг хүртэж буй иргэд, байгууллагууд /хэрэглэгч/-ын хоорондын харилцаа, гэрээ байгуулах нөхцөл, түүнд тавих шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл зэрэг харилцааг зохицуулахад оршино.

### 2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хоорондын аж ахуйн харилцаа

2.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол Улсын Иргэний хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, холбогдох бусад хууль эрх зүйн баримт бичиг болон энэхүү дүрэмд нийцүүлэн хэрэглэгчтэй аж ахуйн гэрээ байгуулна.

2.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгчтэй цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээ байгуулж, дүгнэн ажиллана.

2.3 Иргэнтэй байгуулах гэрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан зүйлийг тусгана.

2.4 Хуулийн этгээдтэй байгуулах гэрээнд энэ дүрмийн 2.3-т зааснаас гадна ус хангамжийн хэрэглээний горим, сар бүрийн төлбөрийн хуваарь зэргийг тусгана.

2.5 Дараах шаардлагыг хангасан хэрэглэгчтэй цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээг байгуулна. Үүнд:

2.5.1 Хангагчаас техникийн нөхцөл авсан байх,

2.5.2 Хэрэглэгчийн эзэмшилд байгаа шугам сүлжээний эзэмшлийн заагийг тогтоосон холболтын схем зурагтай байх /ажлын зургийг хангагчтай зөвшилцсөн байх/;

2.5.3 Хэмжих хэрэгслийн зангилаа, тоног төхөөрөмж нь батлагдсан зураг, схемийн дагуу угсрагдсан, баталгаажуулсан тоолуур суурилуулсан байх,

2.5.4 Цэвэр усны шугамын угаалга, дүүргэлт, холболтын хөлс төлсөн байх,

2.5.5 Гүйцэтгэлийн зураг үйлдэж, хотын мэдээллийн санд бүртгүүлсэн байх.

2.5.6 Ариутгах татуургын төвлөрсөн системд холбогдох боломжгүй хэрэглэгч бохир ус зөөвөрлөх үйлчилгээгээр эрх бүхий байгууллагатай гэрээ хийсэн байх

2.6 Хэмжих хэрэгсэл, лац, тойрох шугам дээрх хаалт, хэмжих хэрэгслийн зангилаа, барилга байгууламж болон гадна цэвэр, бохир усны худаг, худаг хүртэлх шугамын ашиглалтыг хэрэглэгчийн талаас эрх бүхий албан тушаалтанд хариуцуулна.

2.7 Цэвэр, бохир усны үйлчилгээнд хамаарч буй барилга байгууламжийг өөр этгээдийн өмчлөл, эзэмшилд шилжүүлвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг 7 хоногийн өмнө цуцалж, төлбөр тооцоог дуусган, акт үйлдсэн байна.

2.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн хүсэлтээр төлбөртэй үйлчилгээг үзүүлж болно. Үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг хангагч байгууллагаас батална.

### 3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчдийг Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн<sup>1</sup> 6 дугаар зүйлийн 6.5, 6.6 дах хэсэгт заасны дагуу батлагдсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа "MNS 0900:2005 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт" ундны усны стандартын шаардлагад нийцсэн усаар хангах үүрэгтэй.

3.2 Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон шугам сүлжээ, барилга байгууламжид хяналт тавьж, хэрэглэгчид ашиглалтын талаар мэргэжлийн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх үүрэгтэй.

3.3 Хэрэглэгчийн зүй бус усны хэрэглээг илрүүлэх, усны алдагдлыг таслан зогсоох, усыг хэмнэлттэй хэрэглэх бодлого баримтлах, хэрэглэгчийн нийлүүлж буй бохир усанд лабораторийн шинжилгээ хийж, байнгын хяналт тавих үүрэгтэй.

3.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д заасан хэмжээг баримтлан үйлдвэрлэл явуулж буй хэрэглэгчийн технологийн хэрэглээнээс гарч буй бохир уснаас сар бүр дээж авч шалгах эрхтэй.

3.5 Эрх бүхий байгууллагаас усны үнэ тарифт нэмэлт өөрчлөлт оруулсан тохиолдолд түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлах үүрэгтэй.

3.6 Хууль тогтоомж буюу гэрээг санаатайгаар зөрчиж цэвэр, бохир усны шугамд зөвшөөрөлгүй холбосон бол тухайн ус хэрэглээний тооцоог шугам угаалга, дүүргэлтийг тооцох аргачлалаар бодож тогтоон нөхөн төлбөр төлөхийг шаардах эрхтэй. /Шугам дүүргэлт, угаалга тооцох аргачлалаар бодож тогтооходоо урсгалын хурдыг 1.5 м/с гэж үзэж, хоолойн хөндлөн огтлолын талбайгаар тооцно/

3.7 Хэрэглэгчийн эзэмшлийн ариутгах татуургын шугам сүлжээнд хур тунадасны ус оруулсан тохиолдолд нийлүүлсэн усны хэмжээг шугамын дүүргэлтийг 100%, урсгалын

---

<sup>1</sup> 6.5.Стандартчиллын техникийн хорооны хэлэлцэж дэмжсэн стандартын төслийг Стандартчиллын Үндэсний зөвлөл улсын хэмжээнд хэрэглэхээр хүлээн зөвшөөрч үндэсний стандартаар батална.

6.6.Үндэсний стандарт нь товчилсон тэмдэглэгээ, улсын бүртгэлийн дугаартай байх бөгөөд түүнийг баталсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол улсын бүртгэлд бүртгэсэн тухай олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

хурдыг 1.0 м/с байхаар төлбөрийг тооцоолж, хэрэглэгчээр төлүүлэхээр шаардах эрхтэй.

3.8 Хэрэглэгч усыг гэрээнд зааснаас бусад зориулалтаар ашиглаж байгаа нь тогтоогдвол уг зөрчлийг арилгах хугацаатай үүрэг өгөх, мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж хариуцлага тооцуулах, гэрээг цуцлах эрхтэй.

3.9 Хэрэглэсэн цэвэр ус, нийлүүлсэн бохир усны төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчдийг цэвэр усаар хангах гэрээг цуцлах эрхтэй.

3.10 Хэрэглэгчийн буруугаас ус хангамж, ариутгах татуургын системд гэмтэл гаргасан тохиолдолд учирсан хохирлыг барагдуулахыг хэрэглэгчээс шаардах эрхтэй.

#### 4. Хэрэглэгчийн эрх, үүрэг

4.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий албан тушаалтныг сар бүр усны тоолуурын заалт авах боломжоор хангах, баталгаажуулах, төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй.

4.2 Хэрэглэгч өөрийн эзэмшлийн цэвэр, бохир усны шугам, худгийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж, стандартын тагтай байлгах ба техникийн өрөө, зоорийн давхрыг зориулалтын бусаар ашиглахыг хориглоно.

4.3 Өөрийн зааг эзэмшилд байгаа ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ барилга байгууламжийг гэмтээхгүй, усанд автуулахгүй, хөлдөөхгүй байлгах, худгийн тагийг цас мөснөөс цэвэрлэх, хангагч байгууллагаас тавьсан лац, ломбыг гэмтээхгүй байх, гадаргуугийн болон хур тунадасны ус зайлуулах сувгийг ариутгах татуургын шугам сүлжээнд холбохгүй байх, галын гидрантын ашиглалтын бүрэн бүтэн байдлыг хангах, ус зөөвөрлөх боломжтой орц гарцтай байх зэрэг хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүрэгтэй.

4.4 Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид гарсан осол гэмтлийн талаар хангагч байгууллагад яаралтай мэдэгдэж, Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөл ирэх хүртэл гэмтэл гарсан хэсгийг хяналтандаа байлгана.

4.5 Хэмжих хэрэгслийн зангилааг Барилгын норм ба дүрмийн дагуу үзлэг, үйлчилгээ хийхэд тохиромжтой, ус тусгаарлагчтай, гэрэлтүүлэгтэй, +5°C-ээс доошгүй хэмтэй өрөөнд буюу дулааны узелийн өрөөнд байрлуулна.

4.6 Усны тоолуурыг холбогдох журмын дагуу хэрэглэгч өөрийн хөрөнгөөр суурилуулах бөгөөд ашиглалт, үйлчилгээг хариуцна.

4.7 Хэрэглэгчийн усны тоолуур гэмтсэн тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид мэдэгдэж, засварлуулах арга хэмжээг авах үүрэгтэй.

4.8 Хэрэглэгч усны нөөц тоолууртай бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчийг байлцуулан сольж, заалтыг 2 тал баталгаажуулна.

4.9 Хэрэглэгчийн усны хэрэглээ үндэслэлгүй, огцом өөрчлөгдсөн тохиолдолд хэмжих хэрэгслийн зангилааг тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцсөн зөрчлийг арилгуулна.

4.10 Хэрэглэгч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт заасан зөвшөөрөгдөх хэмжээнд нийцсэн бохир усыг төвлөрсөн шугамд нийлүүлнэ.

4.11 Хэрэглэгч нь MNS 6561:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагад нийцсэн цэвэршүүлсэн бохир усыг байгальд нийлүүлнэ.

4.12 Худаг, камерийн бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, гадны хүн оруулахгүй байх нөхцлийг бүрдүүлнэ..

4.13 Хэрэглэгчийн ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд өөр хэрэглэгчийг холбох бол зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зөвшөөрлөөр холбож, эрх бүхий ажилтны хяналтан дор холболтыг гүйцэтгэнэ.

4.14 Хэрэглэгч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх бүхий ажилтанд ус түгээгүүрийн оруулга, усны тоолуурын зангилаа, сантехникийн хэрэгсэл /ванн, тосгуур, угаагуур, жорлон/-ийг шалгах бололцоогоор хангана.

4.15 Өөрийн эзэмшлийн шугам сүлжээнд хангагчтай зөвшилцөлгүйгээр бусад хэрэглэгчийг холбох, тэдгээртэй усаар хангах аж ахуйн гэрээ байгуулахыг хориглоно.

## 5. Усны үйлчилгээний төлбөр тооцоо

5.1 Цэвэр, бохир усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

5.2 Усны хэрэглээний төлбөрийг Монгол Улсын стандартад нийцсэн, эрх бүхий байгууллагын баталгаажуулсан тоолуурын заалтаар тооцох бөгөөд тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.2-д зааснаар тооцно.

5.3 Хэрэглэгч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөлөгчийг тоолуурын заалт авах боломжоор хангаагүй тохиолдолд хэрэглэсэн цэвэр ус, татан зайлуулсан бохир усны хэмжээг сүүлийн 3 сарын дунджаар, шинээр холбогдсон хэрэглэгчийн хувьд хэрэглэсэн усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.2-д зааснаар, тоолуургүй хэрэглэгчийн тарифаар тооцно.

5.4 Ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэгдэж байгаа бохир усны хэмжээг тооцохдоо цэвэр усны хэрэглээг үндэслэнэ.

5.5 Бохир усны хэмжээг хүнсний болон зарим онцлог үйлдвэрийн газруудын бүтээгдэхүүнд шингэсэн усны хэмжээг хасаж тооцно. Үйлдвэрийн газрууд нь шингээлтийн хэмжээг зохих технологийн дагуу тогтоож, хангагчтай тохиролцон, гэрээнд тусгана.

5.6 Усны төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд хангагчийн харилцах дансанд эсвэл тусгай зөвшөөрөл эзэмшигчийн кассанд тушаана.

5.7 Хэрэглэгч худалдан авсан цэвэр ус, нийлүүлсэн бохир усны төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Иргэний хуулийн<sup>2</sup> 232 дугаар зүйлийн 232.6 дах хэсэгт заасны дагуу хангагч нь алданги тооцох эрхтэй.

5.8 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д заасны дагуу батлагдсан цэвэр, бохир усны үнэ, тарифыг дагаж мөрдөнө.

## 6. Ус хангамжийг хязгаарлах нөхцөл

6.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2-т заасан үндэслэлээр хангагч нь хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлана.

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлахдаа урьдчилан мэдэгдэх бөгөөд төлөвлөгөөт засвар, үйлчилгээ хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагааг түр зогсоохдоо онцгой объект болон их хэрэглээтэй хэрэглэгчдэд 24-өөс доошгүй цагийн өмнө, урьдчилан мэдэгдэж, тохиролцсоны үндсэн дээр зогсоох үүрэгтэй.

6.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь бохир усны найрлага дах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх хэмжээнээс ихийг цэвэрлэх байгууламжид нийлүүлсэн, бохирдолтын түвшинг баримтлаагүй тохиолдолд Ус бохирдуулсаны төлбөрийн тухай хуулийн дагуу торгууль ногдуулах, хэрэглэгчийг цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг тодорхой хугацаанд хэсэгчлэн болон бүрэн зогсоож болно.

6.4 Хэрэглэгч нь тусгай зөвшөөрөл эзэмшигчээс албан ёсоор зөвшөөрөл аваагүй тохиолдолд дамжин хэрэглэгчийн усыг хаах болон таслах эрхгүй.

6.7 Хэрэглэгч цэвэр, бохир усны төлбөрөө 3-н сараас дээш хугацаагаар төлөөгүй, ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хэрэглэгчийн ус хангамжийг хязгаарлаж болно.

## 7. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд ажиллах

7.1 Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдал үүссэн үед хангагч өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллана.

7.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь байгаль цаг уурын онцгой нөхцөл байдалд ажиллах журмыг баримтлан шугам сүлжээнд гарсан осол, гэмтлийг богино хугацаанд арилгах бүх талын арга хэмжээ авах, шаардагдах засварын хугацааг хэрэглэгчид хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр мэдээлнэ.

7.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-т заасан<sup>3</sup> гамшгийн нөхцөл байдал үүссэнээс бусад үед буюу шугам сүлжээ, тоног төхөөрөмжид эвдрэл,

<sup>2</sup> 232.6.Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.

<sup>3</sup> 4.1.2."гамшиг" гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг;

гэмтэл гарснаас хэсэг бүлэг хэрэглэгчийн ус хангамж тасарсан тохиолдолд хэрэглэгчид мэдэгдсэнээс хойш 24 цагийн дотор хэрэглэгчийн ус хангамжийг сэргээнэ.

## 8. Маргааныг хянан шийдвэрлэх, хохирлыг нөхөн төлүүлэх

8.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-д заасны дагуу шийдвэрлэнэ.

8.2 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5-д заасны дагуу өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хянан шийдвэрлэнэ.

8.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд гарсан маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу шийдвэрлэх бөгөөд харилцан шийдэлд хүрч чадаагүй тохиолдолд Зохицуулах байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ. Хэрэв маргалдагч талууд Зохицуулах байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд нэхэмжлэл гарган шийдвэрлүүлнэ.

8.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд усны тоолуурын заалттай холбоотой гарсан маргааныг эрх бүхий лаборатори, мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

8.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрэглэгчийн хооронд цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулахтай холбоотой харилцаанаас үүссэн хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хамтран тогтоосон актаар баталгаажуулна.

8.6 Хохирлын актыг холбогдох талууд хамтран ажлын 5 /тав/ хоногийн дотор тогтоож баталгаажуулах бөгөөд хохирлыг буруутай тал нь 1 /нэг/ сарын дотор нөхөн төлнө.

8.7 Хэрэглэгч нь өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийгээгүйгээс тусгай зөвшөөрөл эзэмшигч болон бусад этгээдэд хохирол учруулсан бол хохирлыг шууд нөхөн төлнө.

8.8 Хэрэв хэрэглэгчийн буруугаас тоолуурын хэвийн ажиллагааг хангаагүй, тоолуурын заалтаар усны хэмжээг тооцох боломжгүй тохиолдолд тухайн сарын хэрэглээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20.2-д зааснаар тооцно.

8.9 Дараах тохиолдолд хэрэглэгчид учирсан хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцахгүй. Үүнд:

8.9.1 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16.1, 16.2-т заасны дагуу хязгаарлалт хийснээс учирсан хохирлыг хариуцахгүй.

8.9.2 Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8.ж хэсэг<sup>4</sup> заасан галын болон байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлээс үүдэлтэй хохирол;

8.9.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээгээр тохиролцож, тогтоосон горимыг хэрэглэгч зөрчсөн үед;

<sup>4</sup> 4.1.8.ж.галын болон байгалийн гэнэтийн аюул, эсхүл давагдашгүй хүчин зүйл /усны үер, ган, зуд, аюултай цасан болон шороон шуурга, газар хөдлөлт/ зэрэг шалтгааныг.



8.9.4 Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5-д заасны дагуу хэрэглэгчийн усыг хязгаарласан;

8.9.5 Хэрэглэгчийн ус хангамжийн шугам сүлжээг гуравдагч этгээд гэмтээсэн бол;

#### 9. Бусад зүйл

9.1 Энэхүү дүрмийн биелэлтэд Зохицуулах байгууллага хяналт тавих бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгч талууд хэрэгжүүлнэ.

9.2 Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага болон олон нийт хяналт тавьж болно.

9.3 Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн шугам хоолой, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар үйлчилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх тохиолдолд тэдний хооронд байгуулсан гэрээний дагуу зохицуулна.

-----o O o-----

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 74 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт

## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДЫН ХООРОНДЫН АЖ АХУЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрмийн зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулахтай холбогдон үүсэх аж ахуйн харилцааг зохицуулах, тэдгээрийн хооронд байгуулах гэрээний нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл, тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Энэхүү дүрмийг хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд дагаж мөрдөнө.

### Хоёр. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын аж ахуйн харилцаа

2.1. Усаар хангаж буй болон дамжуулан түгээж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчид /цаашид тусгай зөвшөөрөл эзэмшигчид гэх/ аж ахуйн гэрээгүйгээр ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

2.2. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид хоорондын аж ахуйн гэрээг Зохицуулах байгууллагын баталсан энэхүү дүрмийг үндэслэн Монгол Улсын Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн байгуулж, гэрээг жил бүр дүгнэн ажиллана.

2.3. Гэрээнд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан зүйлийг тусгахаас гадна ус хангамжийн хэрэглээний горим, сар бүрийн төлбөрийн хуваарь зэргийг тусгана.

2.4. Дараах шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах гэрээг байгуулна. Үүнд:

2.4.1. Зохицуулах байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байх бөгөөд барилга байгууламж нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад тэмдэглэгдсэн байна.

2.4.2. Барилга байгууламжууд ашиглалтанд орж, Улсын комисс хүлээн авсан байх /актуудыг хавсаргах/,

2.4.3. Хангагчаас техникийн нөхцөл авсан байх,

2.4.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эзэмшилд байгаа шугам сүлжээний эзэмшлийн заагийг тогтоосон холболтын схем зурагтай байх, /ажлын зургийг хангагчтай зөвшилцсөн байх/

2.4.5. Усны тоолуурын узель нь батлагдсан зураг, схемийн дагуу угсрагдсан, баталгаажигдсан тоолуур суурилуулсан байх,

2.4.6 Гүйцэтгэлийн зургийг хийлгэж, хотын мэдээллийн санд бүртгүүлсэн байх,

2.4.7. Шугамын угаалга, дүүргэлт, холболтын хөлс төлсөн байх,

2.5. Усны параметр гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигчид акт үйлдэж, усны суурь хураамжийг суурь хураамж тооцох аргачлалын дагуу тооцох ба гэрээгээр хүлээсэн хариуцлагыг буруутай тал хүлээнэ.

2.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хариуцсан барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээг өөр тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх тохиолдолд Зохицуулах байгууллагад хүсэлт гаргаж, тусгай зөвшөөрлийн хавсралтад өөрчлөлт хийлгэсний үндсэн дээр гэрээг шилжүүлнэ.

2.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд байгуулсан аж ахуйн гэрээ өөрчлөгдөх, дуусгавар болсон тохиолдолд хэрэглэгчдийн эрх ашгийг хохироохгүйгээр зохицуулсан байна.

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигч талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээнд оролцогч талуудын аль нэг нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хоорондын тооцооны тарифт зохицуулалт хийлгэхийг хүсвэл саналаа Зохицуулах байгууллагад тавьж, шийдвэрлүүлэх эрхтэй.

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээний хугацаанд худалдан авах цэвэр ус, нийлүүлэх бохир усны тоо хэмжээг үндэслэлтэй тогтоох үүрэгтэй.

3.3 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь цэвэр усны шугамын даралтыг гэрээнд заасанаас бууруулахгүй байх үүрэгтэй.

3.4 Гэрээт тусгай зөвшөөрөл эзэмшигчид тоолуур, хэмжих хэрэгсэлд сард нэгээс доошгүй удаа хамтарсан үзлэг шалгалт хийх үүрэгтэй.

3.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төлбөр тооцооны хэмжих хэрэгсэлд хяналт тавих зорилгоор хяналтын хэмжих хэрэгсэл тавих эрхтэй.

3.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн эзэмшлийн усны тоолуурын баталгаат хугацаа дуусахад өөрийн зардлаар тоолуур, хэмжих хэрэгслийг баталгаажуулах үүрэгтэй.

3.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хууль тогтоомж буюу гэрээг санаатайгаар зөрчиж цэвэр, бохир усны шугаманд холбосон бол ус хэрэглээний тооцоог шугам угаалга, дүүргэлтийг тооцох аргачлалаар бодож тогтоон, нөхөн төлбөр төлөхийг шаардах эрхтэй. /Шугам дүүргэлт, угаалга тооцох аргачлалаар бодож тогтоохдоо урсгалын хурдыг 1.5 м/с гэж үзэж, хоолойн хөндлөн огтлолын талбайгаар тооцно/

3.8. Дамжуулан түгээсэн цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөрийг удаа дараа хугацаанд нь төлөөгүй нөхцөлд хангагч нь дамжуулан түгээсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчээс төлбөрийг бүрэн төлөх тухай баталгаа гаргуулахыг шаардах эрхтэй ба дамжуулан түгээгч тал биелүүлэх үүрэгтэй.

3.9 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Иргэний хууль, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрэмд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

#### Дөрөв. Үйлчилгээний чанарын шаардлага

4.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид аж ахуйн гэрээнд заасан тоо хэмжээ, усны чанарын стандартын шаардлага хангасан усаар хангана.

4.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэмтэл, саатлаас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулна.

4.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид хэрэглэгчдийг цэвэр усаар тасралтгүй хангах, бохир усыг татан зайлуулахад шаардагдах ажиллах хүч, материал, тоног төхөөрөмж, машин механизмыг байнгын бэлэн байдалд байлгана.

4.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид нь аюулгүй ажиллагааны дүрэм болон холбогдох бусад дүрэм журамд заасан техникийн нөхцөл, шаардлага, шуурхай үйлчилгээний хэм хэмжээг баримтлан ажиллана.

4.5. Аж ахуйн харилцааны гэрээтэй холбогдсон өргөдөл, гомдлыг ажлын 10 хоногийн дотор хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй тохиолдолд эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

#### Тав. Төлбөр тооцоо

5.1. Төлбөр тооцох цэвэр, бохир усны хэмжээг Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу тогтооно.

5.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчид Зохицуулах байгууллагаас баталсан усны үйлчилгээний тарифыг мөрдөнө.

5.3. Тооцох хэмжих хэрэгслийн хэмжилтийн зөрчлийг итгэмжлэгдсэн эрх бүхий мэргэжлийн хөндлөнгийн лабораториор шийдвэрлүүлэнэ.

5.4. Хэмжүүрээр тооцох цэвэр, бохир усыг сар бүр тусгай зөвшөөрөл эзэмшигчид хамтран хянаж, актаар баталгаажуулна

5.5 Ажилтны буруугаас гарсан төлбөр тооцооны зөрүүг тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан тохиролцож дараа сарын тооцоонд оруулан нөхөн тооцоо хийнэ.

5.6. Гэрээнд цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр хийх хугацааг тодорхой тусган, мөрдөж ажиллана.

5.7 Төлбөрөө хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дах хэсэг<sup>1</sup> заасны дагуу тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төлөгдөөгүй мөнгөн дүнгийн хувиар алданги тооцох эрхтэй.

Зургаа. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хоорондын аж ахуйн харилцаанаас үүссэн хохирлыг тооцох, нөхөн төлөх

6.1. Аж ахуйн харилцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс бусдад учирсан хохирлыг буруутай тал хариуцна.

6.2. Цэвэр, бохир усны аж ахуйн гэрээг зөрчсөн хохирлыг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хамтарсан актаар баталгаажуулна. Үүнтэй холбогдсон гомдлыг Зохицуулах байгууллагад тавьж болно.

6.3. Хохирлын актыг холбогдох талууд хамтран 14 хоногийн дотор тогтоож баталгаажуулах бөгөөд хохирлыг буруутай тал нөхөн төлнө.

6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд заасны дагуу ус хангамжийг тасалсан, хязгаарласнаас үүссэн хохирлыг аль нэг тал хариуцахгүй.

Долоо. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн нөхцөлд ажиллах журам

7.1. Давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас баталсан "Гамшгийн үед хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хариуцсан байгууллагын ажиллах журам" -ыг мөрдлөг болгон ажиллана.

Найм. Маргааныг хянан шийдвэрлэх

8.1 Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд цэвэр ус худалдах, худалдан авах, бохир ус нийлүүлэх, бусад гэрээнд заагдсан үйлчилгээтэй холбогдож үүссэн аливаа маргааныг тусгай зөвшөөрөл эзэмшигчид харилцан шийдвэрлэх бөгөөд хэрэв зөвшилцөлд хүрч чадахгүйд хүрвэл Зохицуулах байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

<sup>1</sup> 232.6.Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.

8.2. Хэрэв Зохицуулах байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

Ес. Дүрмийн биелэлтэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

9.1. Аж ахуйн харилцааны дүрмийн биелэлтэд тусгай зөвшөөрөл эзэмшигчид болон Зохицуулах байгууллага, мэргэжлийн хяналтын байцаагч хяналт тавина.

9.2. Энэхүү дүрмийг зөрчсөн хуулийн этгээдэд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----o O o-----